

Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл

“Замын-Үүд” чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг “Чөлөөт бүсийн тухай хууль”, Тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газартай хийсэн хамтран ажиллах гэрээ, тусгай журмын дагуу олгоно.

Бүрдүүлэх материал:

1. Газрын нэг удаагийн төлбөр төлсөн баримт
2. ОӨУБЕГ-аас олгосон хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын хуудас
3. Бүртгэлийн тэмдэгтийн хураамж төлсөн баримт /44000 төгрөг, хуулийн этгээдийн дансанд/
4. Бүртгэлийн үйлчилгээний хураамж төлсөн баримт /5000 төгрөг, хуулийн этгээдийн дансанд/
5. Бүртгэлийн тэмдэгтийн хураамж төлсөн баримт /44000 төгрөг, “Замын-Үүд” чөлөөт бүсийн ЗАА, Төрийн сан 900036011 дансанд/
6. Бүртгэлийн үйлчилгээний хураамж төлсөн баримт /5000 төгрөг, “Замын-Үүд” чөлөөт бүсийн ЗАА, Төрийн сан 900036011 дансанд/
7. Батлагдсан өргөдлийн маягт
8. Аж ахуйн нэгжийн албан тоот
9. Үүсгэн байгуулагчийн баримт бичгийн хуулбар /иргэний үнэмлэх/
10. Үүсгэн байгуулагчийн шийдвэр, тогтоол, дүрэм
11. Төсөл сонгон шалгаруулалтанд оролцсон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
12. Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх шинээр үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар



ГАЗРЫН ХАРИЛЦАА, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2015 оны 6 сарын 16 өдөр

Дугаар А/64

Улаанбаатар хот

Гэрчилгээний загвар батлах, хэвлүүлэх
тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1, 23.2.13 дахь заалт, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 15.1 дэх заалт, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 2 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Чөлөөт бүсэд газар эзэмших эрхийн гэрчилгээ"-ний загварыг нэгдүгээр, "Чөлөөт бүсэд газар ашиглах эрхийн гэрчилгээ"-ний загварыг хоёрдугаар, Чөлөөт бүсэд газар эзэмших эрхийн гэрчилгээний барааны техникийн тодорхойлолтыг гуравдугаар, Чөлөөт бүсэд газар ашиглах эрхийн гэрчилгээний барааны техникийн тодорхойлолтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Чөлөөт бүсэд газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний эх загварыг бэлтгүүлэх, хэвлүүлэх, орон нутагт хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Кадастрын алба /Р.Ганхуяг/, Санхүү, хяналт шинжилгээний алба /Б.Батсайхан/-д тус тус даалгасугай.

ДАРГА



А.ХҮРЭЛШАГАЙ

0000485



МОНГОЛ УЛС

ЧӨЛӨӨТ БҮСЭД
ГАЗАР АШИГЛАХ ЭРХИЙН

ГЭРЧИЛГЭЭ

Дугаар

ГХГЗЗГ-ын 2015 оны
тушаалын хоёрдугаар хавсралт

Н/ыч

Улаанбаатар / 2015 / 05 / 15

Хүндэтгэсэн / Г.Мөнхтүвшин /

Харгал / Х.Сүхбаатар /

Харгал / Х.Сүхбаатар /

_____ улсын харьяат

_____ -д

(иргэний овог, нэр, хуулийн этгээдийн оноосон нэр)

_____ чөлөөт бүсийн Захирагчийн 20__ оны __ сарын

__ өдрийн __ тоот шийдвэрийг үндэслэн _____ -

(газрын байршлын хааг, нэр)

байрлах нэгж талбарын _____ дугаар бүхий _____ м²/га/

газрыг _____ жилийн хугацаатайгаар _____

зориулалтаар ашиглуулахаар энэхүү гэрчилгээг олгов.

ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

ТАМГА/ ТЭМДЭГ

_____ / _____ /


(гарын үсэг)

(нэр)

20__ оны __ сарын ____



МОНГОЛ УЛС



ЧӨЛӨӨТ БҮСЭД
ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН

ГЭРЧИЛГЭЭ

Дугаар

_____ -Д
(иргэний овог, нэр, хуулийн этгээдийн оноосон нэр)

_____ чөлөөт бүсийн Захирагчийн 20 ____ оны ____ сарын ____

өдрийн ____ тоот шийдвэрийг үндэслэн _____ -
(газрын байршлын хаяг, нэр)

байрлах нэгж талбарын _____ дугаар бүхий _____ м²/га/

газрыг _____ жилийн хугацаатайгаар _____ зориулалтаар

эзэмшүүлэхээр энэхүү гэрчилгээг олгов.

ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

ТАМГА/ ГЭМДЭГ _____ / _____ /
(гарын үсэг) (нэр)

20 ____ оны ____ сарын ____